

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/017/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас:99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ХӨХХӨТӨЛ БАГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ М.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2025.02.21 № 118
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Хөххөтөл багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаанхус сумын Хөххөтөл багийн Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 2,876.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 2,701.3 сая төгрөг зарцуулж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>186,082,941.68</u>	<u>265,882,581.96</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	81,451,530.00	169,143,605.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	81,451,530.00	169,143,605.37
3121	Төгрөг	81,451,530.00	169,143,605.37
31211	Төрийн сангийн харилцах	81,451,530.00	169,143,605.37
33	АВЛАГА	605,769.09	2,793,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	605,769.09	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	2,793,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,025,642.59	93,945,576.59
351	Түүхий эд материал	00.00	601,050.00
35130	Эм боох материал	00.00	601,050.00
354	Хангамжийн материал	104,025,642.59	93,344,526.59
35410	Бичиг хэргийн материал	321,500.00	00.00
35420	Аж ахуйн материал	53,603,015.00	67,996,956.00
35440	Түлш, шатах тослох материал	1,159,000.00	3,047,250.00
35460	Хүнсний материал	18,501,475.59	8,270,570.59
35470	Бусад хангамжийн материал	30,440,652.00	14,029,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,866,528,929.55</u>	<u>2,943,398,823.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,866,528,929.55	2,943,398,823.40
392	Биет хөрөнгө	2,841,695,690.55	2,918,850,232.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,298,553,116.10	3,402,283,106.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-677,972,377.11	-749,772,331.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,500,000.00	115,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,666,666.63	-59,249,999.99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,409,662.00	182,118,652.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,279,627.61	-65,832,057.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,728,500.00	156,878,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,259,084.99	-105,977,655.72
39217	Ном	35,682,168.79	42,902,319.25
393	Биет бус хөрөнгө	24,833,239.00	24,548,591.20
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-834,647.80
39303	Бусад биет бус хөрөнгө	23,410,000.00	23,410,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,052,611,871.23</u>	<u>3,209,281,405.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>8,856,099.76</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	8,856,099.76
413	Өглөг	00.00	8,856,099.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	12,613.76
4136	Бусад өглөг	00.00	8,843,486.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	8,843,486.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,052,611,871.23</u>	<u>3,200,425,305.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,052,611,871.23	3,200,425,305.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	299,861,904.00	299,861,904.00
51101	Өмч: - төрийн	299,861,904.00	299,861,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,355,166,404.87	2,502,979,839.24
51210	Өмнөх үеийн үр дүн	2,355,166,404.87	2,355,166,404.87

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	147,813,434.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	397,583,562.36	397,583,562.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,052,611,871.23</u>	<u>3,209,281,405.36</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,958,850,222.00	2,988,719,606.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,162,200.00	200,543,406.46
120	Нийтлэг татварын бус орлого	4,162,200.00	200,543,406.46
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/	00.00	26,710,376.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,162,200.00	173,833,030.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,162,200.00	3,611,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	3,000,000.00	170,221,330.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,954,688,022.00	2,788,176,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,872,057,374.00	2,711,086,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,866,038,500.00	2,711,086,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	6,018,874.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,648.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,648.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,480,000.00	77,090,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,480,000.00	77,090,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,031,185,987.48	2,840,906,172.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,031,185,987.48	2,840,906,172.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,981,129,093.48	2,771,962,492.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,356,892,795.30	2,048,601,776.85
210101	Үндсэн цалин	952,947,326.30	1,265,688,368.85
210102	Нэмэгдэл	341,810,784.00	675,230,896.00
210104	Урамшуулал	62,134,685.00	107,682,512.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,364,400.00	246,848,429.00
210201	Тэтгэврийн даатгал	116,953,000.00	166,138,773.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,759,000.00	20,629,797.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,007,700.00	10,314,302.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,751,500.00	10,305,691.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,893,200.00	39,459,866.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,605,060.00	79,196,259.91
210301	Гэрэл, цахилгаан	9,218,292.00	9,990,259.91
210302	Түлш, халаалт	70,386,768.00	69,206,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,591,165.00	76,968,008.00
210401	Бичиг хэрэг	6,909,945.00	8,094,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,043,270.00	6,749,961.00
210404	Ном, хэвлэл	119,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,518,950.00	62,124,047.00
2105	Нормативт зардал	152,289,561.00	157,141,965.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,600.00	791,150.00
210502	Хоол, хүнс	152,282,961.00	156,350,815.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,528,500.00	00.00
210604	Урсгал засвар	1,528,500.00	00.00

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,480,600.00	13,677,801.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,162,200.00	3,611,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,318,400.00	10,066,101.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	183,377,012.18	149,528,251.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,261,208.00	15,236,264.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,490,500.00	5,353,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,625,304.18	128,938,936.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,056,894.00	68,943,680.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,056,894.00	68,943,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,056,894.00	54,664,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	14,278,880.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-72,335,765.48	147,813,434.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-72,335,765.48	147,813,434.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,949,831,348.00	2,788,994,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,162,200.00	818,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,162,200.00	818,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,162,200.00	818,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,162,200.00	818,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,948,669,148.00	2,788,176,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,866,038,500.00	2,711,086,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,866,038,500.00	2,711,086,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,648.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,648.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,480,000.00	77,090,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,480,000.00	77,090,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,863,056,965.00	2,665,714,924.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,863,056,965.00	2,665,714,924.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,813,143,675.00	2,596,101,570.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,358,669,063.00	2,047,983,394.00
210101	Үндсэн цалин	954,723,594.00	1,263,387,686.00
210102	Нэмэгдэл	341,810,784.00	676,913,196.00
210104	Урамшуулал	62,134,685.00	107,682,512.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,364,400.00	246,848,429.00
210201	Тэтгэврийн даатгал	116,953,000.00	166,138,773.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,759,000.00	20,629,797.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,007,700.00	10,314,302.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,751,500.00	10,305,691.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,893,200.00	39,459,866.00

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,680,000.00	76,289,999.91
210301	Гэрэл, цахилгаан	9,218,292.00	9,990,259.91
210302	Түлш, халаалт	71,545,768.00	65,299,740.00
210303	Цэвэр, бохир ус	915,940.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	151,043,579.00	145,019,160.00
210502	Хоол, хүнс	151,043,579.00	145,019,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,709,300.00	15,269,766.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,162,200.00	818,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,547,100.00	14,451,466.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,877,333.00	63,890,821.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,798,688.00	50,751,871.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,078,645.00	13,138,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,913,290.00	69,613,354.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,913,290.00	69,613,354.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,913,290.00	55,334,474.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	14,278,880.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>86,774,383.00</u>	<u>123,279,575.37</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,392,000.00	35,587,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,392,000.00	35,587,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,392,000.00	35,587,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,392,000.00	35,587,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-39,392,000.00</u>	<u>-35,587,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	47,382,383.00	87,692,075.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,069,147.00	81,451,530.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	81,451,530.00	169,143,605.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,407,581,244.46	2,187,185,839.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,384,611.00	4,384,611.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,411,965,855.46	2,191,570,450.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	838,960,466.03	838,960,466.03
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	397,583,562.36	2,355,166,404.87	3,052,611,871.23

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	299,861,904.00	397,583,562.36	2,355,166,404.87	3,052,611,871.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	397,583,562.36	2,355,166,404.87	3,052,611,871.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	147,813,434.37	147,813,434.37
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	397,583,562.36	2,502,979,839.24	3,200,425,305.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,984,489,400.00	1,902,448,965.00	2,876,475,800.00	2,701,302,424.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,489,400.00	1,902,448,965.00	2,876,475,800.00	2,701,302,424.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,917,989,300.00	1,852,535,675.00	2,717,223,800.00	2,631,689,070.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,406,244,700.00	1,358,669,063.00	2,092,069,900.00	2,047,983,394.00
210101	Үндсэн цалин	965,353,600.00	954,723,594.00	1,338,470,900.00	1,263,387,686.00
210102	Нэмэгдэл	379,285,800.00	341,810,784.00	699,266,300.00	676,913,196.00
210104	Урамшуулал	61,605,300.00	62,134,685.00	54,332,700.00	107,682,512.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,780,800.00	171,364,400.00	261,508,800.00	246,848,429.00
210201	Тэтгэврийн даатгал	119,530,800.00	116,953,000.00	177,825,900.00	166,138,773.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,062,500.00	13,759,000.00	20,920,700.00	20,629,797.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,250,000.00	11,007,700.00	10,460,400.00	10,314,302.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,812,600.00	2,751,500.00	10,460,400.00	10,305,691.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,124,900.00	26,893,200.00	41,841,400.00	39,459,866.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,680,000.00	81,680,000.00	82,320,000.00	76,289,999.91
210301	Гэрэл, цахилгаан	9,194,800.00	9,218,292.00	10,320,000.00	9,990,259.91
210302	Түлш, халаалт	71,485,200.00	71,545,768.00	71,000,000.00	65,299,740.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	915,940.00	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	161,313,600.00	151,043,579.00	232,806,600.00	145,019,160.00
210502	Хоол, хүнс	161,313,600.00	151,043,579.00	232,806,600.00	145,019,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00	800,000.00	800,000.00

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,087,100.00	9,249,300.00	32,427,900.00	23,538,766.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,162,200.00	818,300.00	818,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,087,100.00	8,087,100.00	31,609,600.00	22,720,466.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,083,100.00	79,729,333.00	98,410,600.00	91,209,321.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,952,400.00	67,598,638.00	85,230,000.00	78,070,371.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,130,700.00	12,130,695.00	13,180,600.00	13,138,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,500,100.00	49,913,290.00	76,132,000.00	69,613,354.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,500,100.00	49,913,290.00	76,132,000.00	69,613,354.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,500,100.00	49,913,290.00	61,853,100.00	55,334,474.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	14,278,900.00	14,278,880.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	2,876,475,800.00	2,788,994,499.91
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,985,802,300.00	1,949,831,348.00	2,711,086,200.00	2,711,086,199.91
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,902,009,400.00	1,866,038,500.00	2,711,086,200.00	2,711,086,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,480,000.00	82,480,000.00	83,120,000.00	77,089,999.91
132001	Орон нутгийн төсвөөс	82,480,000.00	82,480,000.00	83,120,000.00	77,089,999.91
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,162,200.00	1,162,200.00	82,269,600.00	818,300.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,162,200.00	1,162,200.00	818,300.00	818,300.00
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	81,451,300.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,069,147.00	00.00	81,451,530.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	81,451,530.00	81,451,530.00	169,143,605.37

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус сургууль нь 2024 онд "Хүүхдийн амжилттай суралцах бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилгын хүрээнд 8 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сургуулийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/21 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156.7 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	81,451.53	169,143.61	87,692.08
Авлага	605.77	2,793.40	2,187.63

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа материал	104,025.64	93,945.58	(10,080.07)
Үндсэн хөрөнгө	2,866,528.93	2,943,398.82	76,869.89
Нийт хөрөнгө	3,052,611.87	3,209,281.41	156,669.53
Өр төлбөр	-	8,856.10	8,856.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,052,611.87	3,200,425.31	147,813.43
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,052,611.87	3,209,281.41	156,669.53

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 169.1 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 87.7 сая төгрөгөөр өссөн байна.Цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвөөс 70.3 сая, дотуур байрны үйлчилгээнээс 87.8 сая төгрөг, үдийн хоолны зардлаас 6.5 сая төгрөг, сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх төсөвөөс 4.4 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Бараа материал данс оны эцэст 94.0 сая төгрөг болж, оны эхнээс 10.1 сая төгрөгөөр буурсан байна. Эм боох материал 0.6 сая төгрөгийн, аж ахуйн материал 68.0 сая төгрөгийн, түлш 3.0 сая төгрөгийн, хүнсний материал 8.3 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 14.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2 943.4 сая төгрөг болж, 76.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 35.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй хүлээн авсан 170.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 128.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эцэст 8.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, оны эхнээс 8.8 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3 200.4 сая төгрөг болж, 147.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 147.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2 164.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 77.1 сая төгрөг, нийт зарлагыг 2 241.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 1 798.5 сая төгрөгөөр хянаж, 365.6 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 994.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 793.4 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 77.1 сая төгрөгөөр хянаж, баталсан ба тодотгол хийгдээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2 793.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 83.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 2 876.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2 624.2 сая, орон нутгийн төсвөөс 77.1 сая, нийт 2 707.3 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 81.4 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2 701.3 сая төгрөг болж, 93.9 хувийн биелэлттэй, 169.1 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	3,375.50	3,375.50	-	100.0%
2	Хүүхэд хамгаалал	80233	3,586.80	3,584.50	2.30	99.9%
3	Сургалт семинар	80312	2,478.30	2,478.30	-	100.0%
4	Эрүүл мэндийг дэмжих	81605	3,582.00	3,505.05	76.95	97.9%
5	Үдийн цай хөтөлбөр	81801	61,853.10	55,334.47	6,518.63	89.5%
6	Дотуур байрны үйлчилгээ	81806	901,209.50	813,421.93	87,787.57	90.3%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	23,766.00	23,766.00	-	100.0%
8	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	81823	11,378.40	5,334.12	6,044.28	46.9%
10	Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	81834	1,698,293.50	1,633,964.51	64,328.99	96.2%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81835	77,860.80	77,860.74	0.06	100.0%
12	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	81848	818.30	818.30	-	100.0%
13	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	81875	5,153.60	769.00	4,384.60	14.9%
15	Нийтлэг үйлчилгээ ОН		83,120.00	77,090.00		92.7%
	Нийт дүн		2,876,475.80	2,701,302.42	169,143.38	93.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 13.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 149.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг орон тоог баримтлан ажилласан байна. Тус сургуулийн 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 93 хүнд цалин хөлс олгосон байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 90 орон тоо батлагдсанаас 93 хүн ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуульд Pearson /5 дугаар ангийн англи хэл/, Eduten /1-5 дугаар ангийн математик/ хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 326.4 сая төгрөгийн бараа материал, 35.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Оюунтуул, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 031.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 30.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай /өмнөх оноос улсын төсвийн санхүүжилт ихээхэн өссөн/ гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 840.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 42.6 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 / байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 удаа, , байгууллагын батлагдсан төсөв 1 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр 2 удаа, дараа жилийн төсвийн төсөл 1 удаа, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл-1 удаа, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-1 удаа / мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд, дансны код сонголт, цалингийн бичилт, ангилалтай холбоотой 568.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн ба 568.6 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	24 735.0	1	24 735.0	100.0
Нийт дүн	1	24 735.0	1	24 735.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 2.8 төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 2.8 сая төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд 2.8 төгрөгийн залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд: *Залруулсан алдаа*:

- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг Санхүүгийн үр дүнгийн тайланд залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 5.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

5.2 Албан шаардлага

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаартай “Төсвийн шууд захирагч нарт” албан бичгээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшууллыг олгож болно гэснийг үндэслэн, сургуулийн захирлын 2024 оны 08 дугаар сарын 25-ний өдрийн А/23 дугаар тушаалаар 5,026.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

2.Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заалт, ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулалыг холбогдох хууль, журам зөрчиж, тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх., ур чадварын нэмэгдлийг холбогдох шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгож байх талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /хоол хүнсий зардал 200.0 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 35.5 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу илэрхийлсэн.	1	2 793,4	1	2 793,4			1	2 793,4				
Дүн	1	2 793,4	1	2 793,4			1	2 793,4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал, ур чадварын нэмэгдэлтэй холбоотой	1	5 026.0			1	5 026.0						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй.	1	0					1	0				
Дүн	2	0.0			1	5 026.0	1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Улаанхус сумын Хөххөтөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								